



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/222/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН НЭГДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.УРАНЧИМЭГ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/222/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 13,105.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,017,284.93	224,269,444.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	87,329,030.39	177,825,630.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	87,329,030.39	177,825,630.55
3121	Төгрөг	87,329,030.39	177,825,630.55
31211	Төрийн сангийн харилцах	87,329,030.39	177,825,630.55
35	БАРАА МАТЕРИАЛ	31,688,254.54	46,443,813.70
354	Хангамжийн материал	31,688,254.54	46,443,813.70
3541	Бичиг хэргийн материал	154,000.00	
3542	Аж ахуйн материал	5,969,545.00	6,393,545.00
3546	Хүнсний материал	196,000.00	
3547	Бусад хангамжийн материал	25,368,709.54	40,050,268.70
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	390,666,051.19	368,335,406.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	390,666,051.19	368,335,406.81
392	Биет хөрөнгө	377,306,651.13	354,976,006.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	448,873,292.00	448,873,292.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(90,351,866.80)	(111,188,962.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,624,534.00	48,798,334.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,842,002.57)	(39,045,660.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,642,430.00	22,864,430.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,459,640.58)	(16,015,581.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,978,765.00	2,978,765.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,421,319.92)	(2,551,069.92)
39217	Ном	262,460.00	262,460.00
393	Биет бус хөрөнгө	13,359,400.06	13,359,400.06
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,249,999.94)	(1,249,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,359,400.00	13,359,400.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	509,683,336.12	592,604,851.06
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,248,576.69	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,248,576.69	
413	Өглөг	5,248,576.69	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,248,576.69	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504,434,759.43	592,604,851.06
51	Засгийн газрын хувь оролцоо	504,434,759.43	592,604,851.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	229,741,717.00	229,741,717.00
51101	Өмч: - төрийн	229,741,717.00	229,741,717.00
512	Хуримтлагдсан үр дүн	(22,771,115.28)	65,398,976.35
5121	Өмнөх үеийн үр дүн	(22,771,115.28)	(22,771,115.28)
5122	Тайлант үеийн үр дүн		88,170,091.63
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,464,157.71	297,464,157.71
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	509,683,336.12	592,604,851.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	695,605,200.00	1,068,342,894.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,000.00	39,122,399.94
120	Нийтлэг татварын бус орлого	460,000.00	39,122,399.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,949,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	460,000.00	37,138,399.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	695,145,200.00	1,029,220,494.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,645,100.00	888,641,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,645,100.00	888,641,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,500,100.00	140,578,894.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,500,100.00	140,578,894.44
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	709,135,495.75	980,172,802.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	709,135,495.75	980,172,802.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,135,495.75	971,654,202.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,458,853.04	591,621,668.44
210101	Үндсэн цалин	291,181,826.35	372,779,857.00
210102	Нэмэгдэл	98,030,484.14	204,501,760.44
210104	Урамшуулал	15,694,879.00	14,340,051.00
210105	Гэрээт ажлын хөлс	551,663.55	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,633,702.46	75,388,347.06
210201	Тэтгэврийн даатгал	35,547,381.46	52,664,426.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,981,345.00	6,264,581.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,475,939.00	3,114,360.54
210204	Ажилгүйдлийн даатгал	775,879.00	2,876,602.74
210205	Эрүүл мэндийн даатгал	7,853,158.00	10,468,376.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,628,676.69	131,860,317.75
210301	Гэрэл, цахилгаан	7,935,067.21	6,996,398.15
210302	Түлш, халаалт	105,656,953.48	114,713,163.60
210303	Цэвэр, бохир ус	7,036,656.00	10,150,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	802,711.94	23,507,840.78
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		19,538,400.00
210408	Бараа материал акталсны зардал	802,711.94	3,969,440.78
2105	Нормативт зардал	75,160,200.00	89,941,450.00
210502	Хоол, хүнс	75,160,200.00	89,941,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,185,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	5,185,000.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,045,000.00	1,809,166.34
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	1,809,166.34
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,221,351.62	54,055,412.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,487,390.00	16,624,968.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,333,100.00	7,704,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,400,861.62	29,726,444.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,518,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,518,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,518,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(13,530,295.75)	88,170,091.63
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(13,530,295.75)	88,170,091.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	695,145,200.00	1,029,255,494.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	695,145,200.00	1,029,220,494.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,645,100.00	888,641,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,645,100.00	888,641,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,500,100.00	140,578,894.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,500,100.00	140,578,894.44
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	668,492,595.25	933,312,094.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,492,595.25	933,312,094.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	668,492,595.25	924,793,494.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,415,378.25	591,621,668.44
210101	Үндсэн цалин	275,861,123.69	372,779,857.00
210102	Нэмэгдэл	109,032,459.01	204,501,760.44
210104	Урамшуулал	17,970,132.00	14,340,051.00
210105	Гэрээт ажлын хөлс	551,663.55	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,764,027.00	75,388,347.06
210201	Тэтгэврийн даатгал	35,661,981.40	52,664,426.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,986,038.52	6,264,581.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,475,320.40	3,114,360.54
210204	Ажилгүйдлийн даатгал	776,889.88	2,876,602.74
210205	Эрүүл мэндийн даатгал	7,863,796.80	10,468,376.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,380,100.00	137,108,894.44
210301	Гэрэл, цахилгаан	7,935,067.21	6,996,398.15
210302	Түлш, халаалт	100,408,376.79	119,961,740.29
210303	Цэвэр, бохир ус	7,036,656.00	10,150,756.00
2105	Нормативт зардал	74,896,200.00	89,745,450.00
210502	Хоол, хүнс	74,896,200.00	89,745,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,120,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	6,120,000.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,045,000.00	1,809,166.34
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	1,809,166.34
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,871,890.00	25,649,968.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,477,090.00	17,127,968.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,394,800.00	8,522,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,518,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,518,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,518,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,652,604.75	95,943,400.16
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,475,000.00	5,446,800.00
	Дотоод эх үүсвэрээр	3,475,000.00	5,446,800.00
223001	Бусад хөрөнгө		5,446,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,475,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,475,000.00)	(5,446,800.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	23,177,604.75	90,496,600.16
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		87,329,030.39
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		177,825,630.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	(22,771,115.28)	504,434,759.43
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			88,170,091.63	88,170,091.63
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	65,398,976.35	592,604,851.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,116,584,524.83	938,758,894.28	177,825,630.55	84.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,584,524.83	933,312,094.28	183,272,430.55	83.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,065,924.83	924,793,494.28	183,272,430.55	83.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,165,930.39	591,621,668.44	155,544,261.95	79.2
210101	Үндсэн цалин	498,163,130.39	372,779,857.00	125,383,273.39	74.8
210102	Нэмэгдэл	239,282,700.00	204,501,760.44	34,780,939.56	85.5
210104	Урамшуулал	9,720,100.00	14,340,051.00	(4,619,951.00)	147.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,011,600.00	75,388,347.06	11,623,252.94	86.6
210201	Тэтгэврийн даатгал	59,169,400.00	52,664,426.70	6,504,973.30	89.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,959,400.00	6,264,581.02	694,818.98	90.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,480,400.00	3,114,360.54	366,039.46	89.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,480,400.00	2,876,602.74	603,797.26	82.7
210205	Эрүүл мэндийн даатгал	13,922,000.00	10,468,376.06	3,453,623.94	75.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,108,894.44	137,108,894.44		100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,996,398.15	6,996,398.15		100.0
210302	Түлш, халаалт	119,961,740.29	119,961,740.29		100.0
210303	Цэвэр, бохир ус	10,150,756.00	10,150,756.00		100.0
2105	Нормативт зардал	95,193,900.00	89,745,450.00	5,448,450.00	94.3
210502	Хоол, хүнс	95,193,900.00	89,745,450.00	5,448,450.00	94.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00		100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,942,100.00	1,809,166.34	1,132,933.66	61.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,942,100.00	1,809,166.34	1,132,933.66	61.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,173,500.00	25,649,968.00	9,523,532.00	72.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,651,100.00	17,127,968.00	9,523,132.00	64.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,522,400.00	8,522,000.00	400.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,518,600.00	8,518,600.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,518,600.00	8,518,600.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,518,600.00	8,518,600.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,446,800.00	(5,446,800.00)	
	Дотоод эх үүсвэрээр		5,446,800.00	(5,446,800.00)	
223001	Бусад хөрөнгө		5,446,800.00	(5,446,800.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,116,584,524.83	1,029,255,494.44	87,329,030.39	92.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	888,641,600.00	888,641,600.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	888,641,600.00	888,641,600.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,578,894.44	140,578,894.44	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	140,578,894.44	140,578,894.44	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	87,364,030.39	35,000.00	87,329,030.39	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	87,329,030.39		87,329,030.39	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		87,329,030.39	(87,329,030.39)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		177,825,630.55	(177,825,630.55)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжин, багш ажилчдын хөгжлийг хангахад хамтран ажиллаж суралцах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн хамран сургах тойргийн сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах,
- Хичээл, сургалтын үйл ажиллагааг хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах, арга зүйг сайжруулах,
- Хүүхдүүд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцах, эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд суралцах, хөгжих боломжоор хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,921.5 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	87,329.0	177,825.6	90,496.6
Авлага	-	-	-
Бараа материал	31,688.3	46,443.8	14,755.5
Үндсэн хөрөнгө	390,666.0	368,335.4	(22,330.6)

Нийт хөрөнгө	509,683.3	592,604.8	82,921.5
Өр төлбөр	5,248.6	-	(5,248.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	504,434.7	592,604.8	88,170.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	509,683.3	592,604.8	82,921.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 177,825.6 мянган төгрөг болж 90,496.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 46,443.8 мянган төгрөг болж 14,755.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 112,429.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, стем тоглоомын тавиур, цэцэрлэгийн хүүхдийн эцэг эхээс 19,538.4 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, хичээлийн хэрэгсэл, ахуйн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 134,812.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 368,335.4 мянган төгрөг болж 22,330.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,446.8 мянган төгрөгийн сандал, ширээ, аймгийн Боловсролын газраас 1,949.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер үнэ төлбөргүй авч, 29,726.4 мянган төгрөгийн элэгдэл тооцоноос шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 5,248.6 мянган төгрөгөөр буурсан нь 2023 онд үүссэн түлш халаалтын өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 727,073.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,929.0 мянган төгрөг нийт 859,002.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 248,931.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 976,005.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 8,649.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 140,578.9 мянган төгрөгөөр, нийт 1,116,584.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 5 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 888,641.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 140,578.9 мянган төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 35.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 87,329.0 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт **1,116,584.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 202,850.7 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 8,649.9 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 23,037.1 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 8,518.6 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 2,942.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 11,583.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,116,584.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс, урсгал үйл ажиллагаанд 938,578.9 мянган төгрөгийг зарцуулж, 177,825.6 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 938,758.9 мянган төгрөг буюу 84.1 хувьтай байгаа нь хоолны зардлыг 5,448.5 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 167,321.2 мянган төгрөгөөр, бусад зардлыг 5,055.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	976,005.6	798,180.0	177,825.6	81.8
80233 - Хүүхэд хамгаалал	1,256.4	1,255.5	0.9	99.9
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,390.1	1,895.0	495.1	79.3
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	95,193.9	89,745.4	5,448.5	94.3
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,182.6	3,182.2	0.4	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	1,975.1	790.0	1,185.1	40.0
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	850,524.9	683,203.7	167,321.2	80.3
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	21,447.6	18,073.2	3,374.4	84.3
81844 - Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	35.0	35.0	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,578.9	140,578.9	-	100.0
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	140,578.9	140,578.9	-	100.0
ДҮН	1,116,584.5	938,758.9	177,825.6	84.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэг хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	72,156.8	72,156.8	ХТШ
	Нийт дүн	72,156.8	72,156.8	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн/ гүйцэтгэж “Ханангийн хөх бууц” ХХК -тай гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 708,675.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,630.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сайхан сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал – 2 удаа
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 2 удаа,
- Санхүүгийн тайлан – 1 удаа
- Дараа жилийн төсвийн төсөл - 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудагд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар

илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/55 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 322.1 мянган төгрөгийн төсөвт тусгагдаагүй зардал гаргаж ур чадварын цалин хөлсийг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт, 6,570.6 мянган төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан, төлбөр тооцоог урьдчилан хянаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага, зайлшгүй тохиолдолд 1-ээс илүү зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэхгүй байж, цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх, шилэн дансны мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроосон 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	322.1	1	322.1	100.0
Албан шаардлага	2	6,570.6	2	6,570.6	100.0
Зөвлөмж	2	-	1		50.0
Нийт дүн	5	6,892.7	4	6,892.7	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 198,912.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- 160,639.3 мянган төгрөгийн барилга, шугам сүлжээг капиталжуулан бүртгэхдээ тусдаа 1 хөрөнгө үүсгэн /2 барилгатай мэтээр/ бүртгэж, тоо хэмжээ, ашиглах хугацааг зөрүүтэй тогтоосон,
- Тайлант онд нэмэгдсэн 5,173.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг буруу тогтоосон,
- Үр дүнгийн тайланд 3,969.4 мянган төгрөгийн акталсан хангамжийн бараа материалыг /210901/ бараа үйлчилгээний бусад зардлаар, 29,129.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг бараа үйлчилгээний зардлаар буруу тусган илэрхийлсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна

Аудитаар нийт **555.3** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 6 багшид цэцэрлэгийн хүүхэд амарч буй 8 дугаар сард тусгай хэрэгцээт хүүхэд асарсны нэмэгдэл гэж 265.7 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай” тушаалын 1 дэх “Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс ажилтан А.Баяржаргалд 289.6 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийг бүртгэлд буруу тусган, ашиглах хугацааг буруу тогтоосон	2	165,813.1			2	165,813.1	2	165,813.1				
Зардлыг буруу ангилан бүртгэсэн	2	33,099.3			2	33,099.3	2	33,099.3				
Дүн	4	198,912.4			4	198,912.4	4	198,912.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
8 дугаар сард тусгай хэрэгцээт хүүхэд асарсны нэмэгдэл бодож олгосон	1	265.7	1	265.7								
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгэ эс цалинг давхардуулан бодож олгосон	1	289.6			1	289.6						
Дүн	2	555.3	1	265.7	1	289.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансанд 6 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-			1	-		